



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Ц.МОНХБАТ ТАНАА

2024-04-23 № 01/61

танай -ны № -т

### Аудитын тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналттай холбоотой дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг холбогдох хууль, тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;
2. Хугацаандаа хийгдээгүй удаашралтай байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж яаралтай дуусгах;
3. Хөрөнгө оруулалтаас бий болсон 735.0 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгах;
4. Хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах;

Аудитын тайлантай танилцаж, тайланд дурдсан зөрчлийг арилган, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас 30 хоногийн дотор, өгсөн зөвлөмжийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Доржбат/-д зөвлөж байна.

Хавсралт ... хуудастай.



Дундговь аймаг дахь  
Төрийн аудитын газар



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГО  
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-д  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: /ДУА-2024/18-10-ШТА-НА/**

Дундговь дахь Төрийн аудитын  
газрын Дарга, тэргүүлэх аудитор  
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим  
хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон угс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Дарга, тэргүүлэх аудитор Р.Монхтогтох	Дурслэлийн товьёг	6
	<b><u>Бүлэг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд бүрэн нийцүүлэж толөвлөгүй, зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгэгүй удаашралтай, үр дүнг нь тооцож ажиллаагүй байна.</u></b>	
Аудитын менежер	A. Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй зөрчил өмнөх оноос буурсан ч бүрэн арилаагүй байна.	7-9
X.Наранцааграл	B. Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ удаашралтай байна.	9-11
Ахлах аудитор	B. Хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцож ажиллаагүй байна.	13-14
T.Батсайхан		
Аудитор		
Б.Гантуяа		
<i>Аудитын тайлан, дүгнэлтийн холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харшигана уу.</i>	<b>Дүгнэлт</b>	
<i>ХАЯГ:</i>	<b>Зөвлөмж</b>	
<i>Сайнцагаан сум 7-р баg, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот</i>	<b>Шалгагдагч байгууллагын санал тайлбар</b>	
<i>2024 оны 4 дүгээр сар</i>	<b>Тайлангийн хавсралтууд</b>	



## Тайлан баталгаажуулах тушаал



ДҮНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 23 одөр

Дээдээр A/08

Майданын

### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан / ДУА-2024/18-10-ШТА-ГА / -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (акт, албан шаардлага)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

1. “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсон албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн ханггуулан, үр дүнгийн талаар 2024 оны 11 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн, Засаг дарга /Ц.Мөнхбат/-д зөвлөсүгэй.

Аудитаар өгсон зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2024 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/ аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МОНХТОГТОХ

## ТОВЧИЛСОН УГС

<b>АДБОУБ</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>АИТХ</b>	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>TAX</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ХБТХОХ</b>	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
<b>ОНХО</b>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<b>ОНТХО</b>	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
<b>ХО</b>	Хөрөнгө оруулалт

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитын зорилт:

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тусгасны дагуу “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийлээ.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- ✓ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Эрчим хүчний тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- ✓ Дундговь аймгийг 2021- 2026 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлاغнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий

*Аудитын хамарсан хүрээ:*

дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг Дундговь аймагт 2023 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн хүрээнд үндэслэн хийсэн.

Аудитын явцад объект дээр ажиллаж, барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

*Аудитын арга зүй:*

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын гүйцэтгэл, тайлagnalын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацral үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын З-р нэгжийн ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа нар 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дугаар сарын 11-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 818.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 83.6 сая төгрөгийн зөрчил арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, аймгийн Засаг даргад 735.0 сая төгрөгийн З заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

*Аудит хийх багийн  
бүрэлдэхүүн, хугацаа:*

*Аудитын дүн*

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 64 тоот тогтоолоор нийт 3,491.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 TAX-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсныг аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 удаа өөрчлөлт оруулан, нийт дүнг 1,744.8 сая төгрөгөөр буюу 50.0 хувиар нэмэгдүүлэн 43 төсөл арга хэмжээ болгож баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч компаниудтай нийт 4,984.1 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үнээс гүйцэтгэлээр тайлант онд 4,431.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Xүснэгт 1	ОНХО-ын батлагдсан TAX, тодотголоор хийгдсэн өөрчлөлт	7
Xүснэгт 2	Хөрөнгө оруулалт, TAX-ний нийцэл	8
диаграмм	ОНХО-ын төлөвлөлт	8



**БҮЛЭГ А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд бүрэн нийцүүлж төлөвлөөгүй, зарим төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, удаашралтай, үр дүнг тооцож ажиллаагүй байна.**

**A.1 Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй, зөрчил өмнөх оноос буурсан ч бүрэн арилаагүй байна.**

*A.1.1 Төсөл, арга хэмжээний 24.1 хувь нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.*

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 64 тоот тогтоолоор нийт 3,491.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 TAX-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсныг аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 удаа өөрчлөлт оруулан, нийт дүнг 1,744.8 сая төгрөгөөр буюу 50.0 хувиар нэмэгдүүлэн 43 төсөл арга хэмжээ болгож баталсан байна. Өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв /сая төгрөг/			
		АИТХ-ын тогтоол 2022.12.05 №64	АИТХ-ын тогтоол 2023.03.20 №01	АИТХ-ын тогтоол 2023.06.27 №25	Өөрчлөлт /анх батлагд санаас/
<b>1. Шилжих хөрөнгө оруулалт</b>	<b>152.0</b>	<b>152.0</b>	<b>152.0</b>	<b>152.0</b>	-
Барилга их засвар		20.0	297.1	297.1	297.1
Тоног төхөөрөмж	692.7	1,319.7	1,777.2	1,084.5	
Төсөл арга хэмжээ	927.8	927.8	1,182.8	255.0	
<b>2. Шинэ хөрөнгө оруулалт</b>	<b>1,620.5</b>	<b>2,267.5</b>	<b>3,257.1</b>	<b>1,636.6</b>	
<b>3. Их засвар, арга хэмжээ</b>	<b>1,115.9</b>	<b>1,159.3</b>	<b>1,194.6</b>	<b>78.7</b>	
<b>4. Зам засвар</b>	<b>602.9</b>	<b>602.9</b>	<b>632.4</b>	<b>29.5</b>	
<b>Нийт ОНТХО-ын дүн</b>	<b>3,491.3</b>	<b>4,181.7</b>	<b>5,236.1</b>	<b>1,744.8</b>	
<b>Санхүүжил тийн эх үүсвэр</b>	өмнөх оны үлдэгдлээс	159.9	159.9	159.9	-
	өмнөх оны хэмнэлтээс	68.1	68.1	68.1	-
	тайлант оны санхүүжилт	3,263.3	3,953.7	5,008.1	1,744.8
	<b>дүн</b>	<b>3,491.3</b>	<b>4,181.7</b>	<b>5236.1</b>	<b>1,744.8</b>

Хүснэгтээс харахад TAX-г анхны баталагдсан тогтоолоос 29.5-1,636.6 сая төгрөгөөр нэмж баталжээ. Үүнээс шилжих хөрөнгө оруулалтад их засварын ажлыг шинээр нэмж, харин тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2.6 дахин нэмэгдүүлсэн байна. Төсвийн тодотголоор хамгийн их хэмжээгээр нэмэгдсэн тоног төхөөрөмжийг төрлөөр нь ангилж үзвэл 785.0 сая буюу 72.4 хувийг автотээврийн хэрэгсэл эзэлж байна.


ОНХО-ын бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	Нийцсэн			Нийцэгүй		
	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн	Хувь
"Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"	25	4,027.7	75.9	18	1,279.9	24.1
"Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"	39	5,082.6	97.1	4	153.3	2.9
"Алсын хараа 2050 монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого"	42	5,196.0	99.2	1	40.0	0.8

Нийт төлөвлөсөн ТАХ-ний 1,279.9 сая төгрөгийн 18 ТАХ нь "Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй, 153.3 сая төгрөгийн 4 ТАХ нь "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-тэй, 40.0 сая төгрөгийн 1 ТАХ нь "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-той тус тус уялдаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах тайлагнах журам"-ын 3.1.4<sup>1</sup>-д заасныг зөрчиж байна.



Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөөгүй зөрчил нь өмнөх оноос 19.8-51.2 хувиар буурсан ч өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөлтийг диаграммаар харуулав.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>2</sup>-д заасныг зөрчсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн төслийн саналд хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө судалгаа хийж, нэн тэргүүний чухал ач холбогдолтой төслүүдийг тодорхойлон эрэмбэлж, жагсаалт гарган баримтжуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар

Диаграммаас харахад орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 22.6 хувь буюу 1,182.8 сая төгрөгийг төсөл хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 35.1 хувь буюу 307.4 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх онд 329.0 сая төгрөгийг аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, тэмцээн уралдаан, наадам зохион байгуулах зэрэгт зарцуулсан бол тайлант онд 31.9 хувиар буурсан ч 224.0 сая төгрөгийг хөрөнгийн бус нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд зарцуулжээ.

<sup>1</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах зарчмыг баримталж холбогдох тайлан материалыг хавсарна. Үнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
- Хэрэгцээ шаардлага үндэслэл;
- Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл

<sup>2</sup> "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах” журмын 2.1.2.<sup>3</sup> заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулаагүй, ирээдүйд бий болгох үр ашиг, хэрэгцээ шаардлагыг тооцон эрэмбэлэхгүй төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, зөрчил давтан гарах, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх, ажлын хариуцлага сулрах сөрөг үр дагавартай байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

**Иймд орон нутгийн хэрэгцээ шаардлагын суурь судалгааг жил бүр хийж аймгийг хөгжүүлэх урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, ирээдүйд үр өгөөжисөө өгөх, орон нутгийн хөгжилд тодорхой дэмжслэг болохуйц төсөл арга хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байх шаардлагатай байна.**

*A.1.2. Төсөл, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд бүрэн нийцэгүй байна.*

Тайлант онд төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хуулийн 29.4-т нийцүүлэн хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээг төсөл нэг бүрээр төлөвлөжээ.

Харин өмнөх онд “Багийн ахмадын төв”-ийн зураг төсөвгүй ажлыг 3 удаа төндер зарлан амжилтгүй болсон байхад 2023 онд дахин 40.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Энэ нь:

1. Төсвийн тухай хуулийн 29.4-т /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана/ заасныг зөрчсөн;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д /Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно./ мөн хуулийн 13.1.6-д /үлсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил торлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх/;
3. Багийн ахмадын төвийн хэрэгцээ шаардлагыг судлаагүй /аймгийн ахмадын төвийн ашиглалтын байдал, ачааллыг судлан Сайнцагаан сумын ахмадын хорооны үйл ажиллагааг явуулах боломжийг тооцож үзээгүй/;
4. Шинээр багийн ахмадын төв барьсан тохиолдолд гарах үйл ажиллагааны зардлын төсөв, зардлыг ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжтой зэргийг цогцоор нь тооцож төлөвлөөгүй байна.

Тооцоо судалгаа хийлгүйгээр хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, орон нутгийн төсөвт нэмэлт ачаалал үүсгэх, ашиглалтгүй хөрөнгө бий болох зэрэг үр дагавартай байна.

**Иймд хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн, цаашид гарах үр дагаварыг цогцоор нь тооцож судлан үр ашигтай төсөл арга хэмжээг төлөвлөж байх нь зүйтэй.**

## **Б.1 Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ удаашралтай байна.**

*B.1.2. Зарим төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаа, холбогдох зураг төсов, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй байна.*

Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан 43 төсөл арга хэмжээнээс тайлант хугацаанд хийгдээгүй дараах ажлууд байна. Үүнд:

<sup>3</sup> төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлох, жагсаалт гарах;

- Багийн ахмадын төв /төсөвт өртөг 40.0 сая төгрөг/ өмнөх онд 3 удаа тендер зарласан боловч амжилтгүй болсон, зураг төсөвгүй;
- Хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийг бичигч станц /төсөвт өртөг 9.7 сая төгрөг/-ыг ашиглагч байгууллагаас хэрэгцээ шаардлагагүй тоног төхөөрөмж захиалахаар хүсэлт ирүүлсэн;
- Цагдаагийн газрын албан хэрэгцээнд авто машин нийлүүлэх /төсөвт өртөг 100.0 сая төгрөг/ 2 удаа тендер зарлаад амжилтгүй болсон зэрэг шалтгаанаар тус тус хийгдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 14.4-т */Төсвийн ерөнхийлон захирагч нь төсөв хувсаарлах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй/* заасны дагуу дараах ажлуудыг сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлэн гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Сайнцагаан сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын автомашин нийлүүлэх */2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/255 тоот захирамжаар/*;
2. Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засварын ажил */2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/43 тоот захирамжаар/*
3. Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний засвар хийх */2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/292 тоот захирамжаар/*

Харин гүйцэтгэл дутуу, удаашралтай дараах ажлууд байна. Үүнд:

- Олгойн.govийн ус цэвэршуулэх байгууламжийн барилга шинээр барих ажил 2 удаа тендер зарлаад амжилтгүй болсон тул жилийн эцэст шууд гэрээ байгуулж, газар гэсэхээр хийгдэхээр хүлээгдэж байгаа;
- Залуус хорооллын 205 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажлыг гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан, гүйцэтгэгч компани хийж байгаа ажлаа дуусгаад хийхээр хүлээгдэж байгаа;
- Цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах камержуулалтын ажлын гүйцэтгэл дутуу, гүйцэтгэгч компани тодорхойгүй шалтгаанаар дуусгаагүй байна.



Өмнөх онд бохир усны 458-р худгаас 416-р худаг хүртэл шугамын өргөтгөлийн ажлын тендерийг 3 удаа зарлан, гүйцэтгэгчээр Дундговь ус ОНӨААТҮГ-ыг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Гэрээнд өргөтгөлийн ажлыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр эхэлж, 10 дугаар сарын 25-ны өдөр дуусган ашиглалтад оруулахаар заасан ч хугацаа сунгаагүй, тодорхойгүй шалтгаанаар дуусаагаагүй, удаашралтай байсан тул зөрчлийг арилгуулахаар өмнөх аудитаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Гэтэл тайлант онд дээрх ажил огт хийгдээгүй, захиалагчаас гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6<sup>4</sup>, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.6<sup>5</sup>-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд удаашралтай байгаа бохир усны шугамын өргөтгөлийн ажлыг зураг төсвийн дагуу яаралтай, чанартай хийж дуусгах ажлыг зохион байгуулж зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

*Б.1.2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажилгааг хууль журмын дагуу хийж, үе шатны хяналтыг хэрэгжүүлэх, ашиглалтанд хүлээн авсан байна.*

<sup>4</sup> /гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах/

<sup>5</sup> /төслийн хэрэгжилтийг хууль журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих/



Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 43 ТАХ-нээс 2 ажил хийгдээгүй, 635.3 сая төгрөгийн 3 ажлыг эрх шилжүүлж, 3,132.8 сая төгрөгийн 22 ажилд тендер шалгаруулалт зохион байгуулж, 1,418,1 сая төгрөгийн 16 ажилд шууд гэрээ байгуулжээ.

Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар үнэлгээний хороог тухай бүрд нь байгуулж, тендерийн жишиг баримт бичиг, ирүүлэх шаардлагатай мэдээлэл, тендер шалгаруулах шалгуур үзүүлэлт, захиалагчийн санал болгож байгаа

гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бэлтгэж, худалдан авах ажиллагааны цахим системд нийтэд зарлан мэдээлжээ.

Захиалагчийн байгуулсан үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийн баримттай танилцан, үнэлгээ хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, саналын хувь зэргийг хурлын тэмдэглэлээр баримтжуулсан байна.

Үнэлгээний хорооны хурлын шийдвэрийг үндэслэн тендерт шалгарсан гүйцэтгэгчид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.1<sup>6</sup>-д заасан хугацаанд гэрээ байгуулах тухай, харин бусад оролцогчдод татгалзсан мэдэгдлийг аймгийн ЗДТГ-ын албан бичгээр тухай бүр мэдэгдэл хүргэсэн байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гэрээний үнэ, төлбөр хийх нөхцөл, хэлбэр, урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, захиалагчийн хяналт болон бусад нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа шаардах дүн, хэлбэр, бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь зэргийг тусган баталгаажуулж ажиллажээ.

Бүрэн хэрэгжсэн бүх төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт, дараах ажлуудад зохиогчийн хяналтыг хийж баримтжуулжээ.

- Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засвар;
- Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2 дугаар дотуур байрны барилгын дээврийн их засвар;
- Дэлгэрхангай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн их засвар;
- Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын засвар;
- Сайнцагаан сумын 6-р цэцэрлэгийн барилгын засвар;
- Сайнцагаан сумын Номгон дэлгүүрийн урд замаас сургуулийн гудамж хүртэлх зам талбайн тохижилт.

Хэрэгжүүлсэн 8 төсөл арга хэмжээг хүлээн аваходаа гэрээ дүгнэсэн маягтыг баримтжуулаагүй байна.  
*/Залуус хорооллын 205-р байрны гадна талбайн тохижилт, Луус сумын төрийн албан хаагчдын байрны пасадны засвар, Уламжлалт анагаах ухааны эмнэлэгийн ариун цэврийн өрөөний засвар, Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт, Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын засвар, Сайнцагаан сумын 6-р цэцэрлэгийн барилгын засвар, Дэрэн сумын хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар, Дэрэн сумын эруул мэндийн төвийн ариун цэврийн өрөөний засвар/*

Эн нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.30-д /Төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана/ заасныг зөрчсөн байна.

Иймд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хүлээн аваходаа акт үйлдэн холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, гэрээний үүргийн билэлтийг тооцон гүйцэтгэлд хяналт тавьж хэвших нь зүйтэй.

*Б.1.3. Төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд 735.0 сая төгрөгийн зоруутэй тусгасан байна.*

<sup>6</sup> Захиалагч тендер нээнээс хойши ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлгэдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгаралаагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.



Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,984.1 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулжээ. Гүйцэтгэлээр гэрээний үнийн 88.9 хувь буюу нийт 4,431.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	ХАА-ны төрөл	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Эрх шилжүүлсэн	635.3	796.6	635.3	79.7
2	Тендер зарласан	3,132.8	2,922.8	2,596.8	88.8
3	Шууд гэрээ байгуулсан	1,418.1	1,264.7	1,199.3	94.8
	дүн	5,186.3	4,984.1	4,431.4	88.9

Хөрөнгө оруулалтын санхүүжилт дутуу байгаа нь:

- Дараа онд шилжсэн 5 ажлын 306.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй;
- Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засварын 161.3 сая төгрөгийг тухайн сумын төсвөөс санхүүжүүлсэн;
- 7 төсөл арга хэмжээнээс 84.6 сая төгрөгийг хэмнэсэнтэй тус тус холбоотой байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдэд ажлын гүйцэтгэлийн хэдэн хувьд санхүүжилтийг олгох талаар тодорхой тусгаж, мөрдөж ажилласан. Мөн “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.3.2.4-т заасны дагуу засварын ажил, тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комиссын акт, гүйцэтгэгчийн эцсийн санхүүжилт хүссэн албан бичиг, захиалагчийн тооцоог тус тус үндэслэн санхүүжилтийг олгож баримтжуулсан байна.

Төсөл арга хэмжээг хүлээн авсны дараа хяналтын хуудсыг бичиж ХБТХОХ-ийн дарга, мэргэжилтэн нар баталгаажуулснаар хяналтын хуудсыг үндэслэн санхүүжилтийн тооцоог хийж ажиллажээ.

Аудитын явцад ОНХО-аар хийгдсэн ТАХ-ний гүйцэтгэлийн явцад бий болсон хөрөнгийг НББ-д тусган тайлагнасан байдлыг түүвэрлэн тулгаж үзлээ. Түүвэрлэлтээр нийт 3,494.0 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгийн дансанд орлого авч, санхүүгийн тайланда тусгахаас 2,759.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, 735.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Угийн бичиг хөтлөх аппликешн /19.9 сая төгрөг/
- “ХҮР-ДАН” системийн үйлчилгээний цэгийн тохижилт /19.9 сая төгрөг/
- Эрдэнэдалай сумын Хүүхдийн ордны засвар /691.3 сая төгрөг/ -ыг бүртгээгүй;
- Багийн засаг дарга нарын албан хэрэгцээний мотоцикл /40 ширхэг/ -ийг 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Иймд хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэлийг дахин нягтлах, бүртгэгдээгүй болон зөрүүтэй бүртгэлийн шалтгааныг тогтоож залруулах шаардлагатай.

## B.1 Хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцож ажиллаагүй байна.

### B.1.1. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.



ОНХО-аар нийт 5,236.1 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 149.7 сая төгрөгийн 3 ажил хийгдээгүй, 254.6 сая төгрөгийн 3 ажил удаашралтай гүйцэтгэл 86.0 хувьтай байна. Бүрэн хийгдсэн ажлаас 50.0 сая төгрөгийн өртөгтэй тайзны хөшиг тоноглол ашиглагдаагүй нь Дэлгэрцогт сумын шинэ соёлын төвийн дотор засварын ажил дуусахаар сууринуулахаар хүлээгдэж байна.

Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний хувьд зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

B.1.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч төлөвлөсөн үр дүнг тооцож ажиллаагүй байна.



Төлөвлөсөн арга хэмжээнүүдээс хийгдээгүй 9.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч станцын багаж” нийлүүлэх ажил нь тухайн багажийг ашиглагч байгууллагын хэрэгцээг судлаагүйгээс шалтгаалан хийгдээгүй байна. Энэ нь хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөөгүйгээс тухайн санхүүжилтийн эх үүсвэрээр өөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг алдаж байгааг харуулж байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч үр дүнг тооцож ажиллаагүй байна. Тухайлбал “Дундговь боловсролын чанар төсөл”-ийг хэрэгжүүлэхэд 232.4 сая төгрөгийг зарцуулжээ. Тус хөтөлбөрийн хүрээнд сурагчдын өмнөх жилүүдийн сурлагын үзүүлэлтүүдийг харьцуулан судлаж дүгнэлт хийгээгүй, ямар хичээлүүдэд хоцрогдол бий болсныг тодорхойлоогүй байгаа нь тухайн хөтөлбөрийн зорилго зорилтын хэрэгжилт, ач холбогдлыг үнэлэх боломжгүй болгожээ. Төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө зорилго, зорилтыг нь оновчтой тодорхойлох, хэрэгжүүлсний дараа хөтөлбөрийн үр дүнг өмнөх үеийн үзүүлэлтгэй нь харьцуулж дүгнэвэл ач холбогдлыг нь дүгнэх, дараагийн төсөл хөтөлбөрийг төлөвлөхөд дэмжлэг болохоор байна.

Мөн хөтөлбөр, арга хэмжээ хөрөнгө оруулалтын хүрээнд “Хүний нөөцийг хөгжүүлэх дэд” хөтөлбөрийг баталж, 750.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 674.9 сая төгрөгийг нэгдсэн сургалт, эрүүл мэндийн дэмжлэг, орон сууцны дэмжлэг, сургалтын төлбөр зэрэгт зарцуулжээ. Сургалтын төлбөрийн дэмжлэг олгоходо суралцагчидтай гуравласан гэрээ байгуулж баримтжуулсан байна. Гэвч өмнөх жилүүдэд сургалтын дэмжлэг үзүүлсэн оюутнуудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй, зарим гадаад сургалтуудын баримт материал дутуу үр дүнг тооцохгүй орхиж байгаа нь хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ач холбогдол, үр өгөөжийг бууруулах үр дагавартай байна.

Цаашид боловсон хүчнийг чадавхжуулах, орон нутагт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийхдээ хэрэгцээ шаардлагыг чухалчлах, сонголт хийж байгаа шалгуурыг олон нийтэд ил тод болгох, бүх салбарыг хамарсан судалгааг үндэслэн шийдвэрлэж байх нь зүйтэй.

Иймд дээрх зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй байх, төсөл арга хэмжээнүүдийн үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.



## Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үнд:

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулжс төлөвлөөгүй, зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй удаашралтай байна.**

- ✓ ОНХО-ыг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй бүрэн нийцүүлээгүй баталсан байна.
- ✓ Төсөл арга хэмжээний 12.2 хувь буюу 5 ажил төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй удаашралтай байна.
- ✓ Бөхирын шугамын өргөтгөлийн ажлыг зураг төсвийн дагуу хийж дуусгaaгүй, захиалагч гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ✓ Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжс санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон ч бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн тусгaaгүй байна.

- ✓ Хөтөлбөр арга хэмжээний үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тооцож ажиллаагүй байна.



## Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

### Аймгийн Засаг даргад:

- ✓ ОНХО-ыг холбогдох хууль, тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;
- ✓ Хугацаандаа хийгдээгүй удаашралтай байгаа TAX-ний гүйцэтгэлд хяналт тавьж яаралтай дуусгах;
- ✓ Хөрөнгө оруулалтаас бий болсон 735.0 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгах;
- ✓ Хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах.



## Шалгагдагч байгууллагын санал тайлбар



Т.Батсүрхэц  
Төвийн Баяцаа  
Сүүрэй

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

С.Буянзумжийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын  
ордон, 7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090  
Утас/факс: 70592353 Цахим шүүдэл: info@dundgovi.gov.mn  
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024. 04. 23 № 01/562  
тэйл 2024. 04. 23 № 01/59

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАРТ

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас  
“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө  
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д  
хийсан гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй  
танилцлаа.

Тухайн тайлангийн төсөлд ямар нэг санал,  
тайлбаргүй болно.



4824140337

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг  
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39

E-mail: [dundgovi@audit.gov.m](mailto:dundgovi@audit.gov.m) O